



# НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН 2013 ОНЫ ТАЙЛАН

МОНГОЛ УЛС

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	2
СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ .....	4
БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД .....	6
ХҮН АМ БА ХӨГЖЛИЙН АСУУДЛЫГ УЯЛДУУЛАХ НЬ .....	7
ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ: ХӨГЖЛИЙН ҮНДЭС.....	9
ЗАЛУУЧУУДЫГ НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОЖ, ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ СОНГОХ ЧАДАВХИТАЙ БОЛГОХ НЬ .....	10
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ .....	14



Хавтасны гэрэл зураг  
Израйлийн Тель Авив хотын  
сэтгүүлч, гэрэл зурагчин  
Ашер Свиденскын бүтээл  
болно. Монголын Казак  
анчин эмэгтэйн энэ зураг нь  
Монгол дахь эмэгтэйчүүдийн  
эрх чөлөө, хязгааргүй  
боломж чадварыг илэрхийлж  
байгаа бөгөөд гэрэл зураг  
болон Свиденскын талаарх  
дэлгэрэнгүй мэдээллийг  
[www.svidensky.com](http://www.svidensky.com)  
сайтаас авна уу.

## ӨМНӨХ ҮГ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан нь (НҮБХАС) 2012-2016 онд Улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөрөө: хүн ам ба хөгжил, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, залуучуудын хөгжил, жендэрийн тэгш байдал гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр хэрэгжүүлж байна.

Хүн ам ба хөгжлийн хөтөлбөр нь хүн амын тоон мэдээ, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн, хөгжлийн зорилгод ашиглахад нь засгийн газарт дэмжлэг үзүүлдэг. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр нь эх, нярайн эндэгдлийг бууруулж, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилготой. Залуучуудын хөтөлбөр нь Монголын нийт залуучуудыг амьдрах ухаанд сургаж, чадавхижуулан, харьцааны чадвартай болгоход чиглэдэг. Жендэрийн хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэн, жендэрийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг.

НҮБХАС нь 1970-аад оны сүүлээс Монгол улстай хамтран ажиллаж, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлүүдэд томоохон ахиц гаргав. Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, бодлого боловсруулж шинэчлэх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг үйлчилгээг сайжруулах, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм хэрэгсэл, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэлийг ханган нийлүүлэхэд техник арга зүйн дэмжлэг үзүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд эх, нярайн эндэгдлийг 1990-ээд оны түвшингээс бараг талаас илүү хувиар бууруулж, хүн амын тоон мэдээ мэдээллийг цуглуулж, үр дүнтэй ашиглах тогтолцоог бий болгож, жендэр, залуучуудын чиглэлээр томоохон ахиц гаргалаа.



[www.mongolia.unfpa.org](http://www.mongolia.unfpa.org)



[facebook.com/UNFPA.mongolia](https://facebook.com/UNFPA.mongolia)



[twitter.com/UNFPA\\_mongolia](https://twitter.com/UNFPA_mongolia)

## СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

Хорин жилийн тэртээ 1994 онд 179 орны удирдагчид Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлаар Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг баталсан юм. Уг мөрийн хөтөлбөрийн гол зорилго нь хувь хүмүүс хэзээ хэдэн хүүхэдтэй болохоо өөрсдөө чөлөөтэй шийдэж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээгээ хангаж, мэдээлэл үйлчилгээ авахад нь дэмжлэг үзүүлэхэд оршино. Хүн амын асуудал гэдэг бол дан ганц хүн амын тооллогын асуудал бус харин хүн нэг бүрийг анхаарч үзэх явдал юм гэдгийг тус бага хурлаар дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрсөн билээ.

Монгол улс Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зарчмуудыг тууштай дэмжиж, зорилгыг нь хэрэгжүүлэхэд томоохон амжилт гаргасан бөгөөд цаашид уг мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг хангаж ажиллахаа 2013 онд болсон Ази Номхон далайн хүн амын асуудлаарх VI бага хурал дээр илэрхийлэв. Уг бага хурлын дараа засгийн газар, парламент, иргэний нийгэм, олон улсын байгууллагууд хамтран хүн ам ба хөгжлийн асуудлаар үндэсний дээд хэмжээний уулзалт зохион байгуулсан цөөн хэдэн орны нэг бол Монгол улс юм. Уг дээд хэмжээний уулзалтаар Улаанбаатар тунхаглалыг баталж, цаашид Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг ахиулж, Монгол улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрхийг бүх нийтэд хүртээмжтэй болгож, залуучуудаа хөгжүүлж, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоон, иргэний нийгмийн оролцоог хангаж, эмзэг байдлыг бууруулахаа амлав.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрхийг хангахад 2013 онд томоохон ахиц гарав. Монгол улс 2015 онд хүрэхээр төлөвлөсөн Мянганы хөгжлийн

зорилтоо хугацаанаас нь өмнө биелүүлж, эхийн эндэгдэлийг 100,000 амьд төрөлт тутамд 42.6 болгон бууруулав. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэлд зориулсан төсвөө Засгийн газар бараг 50 хувиар нэмэгдүүлж, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнүүдэд жирэмслэлтээс хамгаалах орчин үеийн шинэ арга хэрэгслүүдийг хүртээмжтэй болгож байна. Энэ нь иргэдэд үзүүлж буй нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чухал ач холбогдолтой бөгөөд үүнтэй уялдуулан НҮБХАС Люксембургийн Засгийн Газартай хамтран бүх аймгуудад телемедицин буюу зайн оношлогооны сүлжээг нэвтрүүлж байна. НҮБХАС Дэлхийн хүн амын байдал тайланг жил бүр гаргадаг бөгөөд 2013 оны тайлангаар өсвөр насны охидын жирэмслэлтийн асуудлыг хөндөж, энэ хүрээнд Монгол улсад өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, өсвөр үеийнхний дунд өсөн нэмэгдэж буй гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээг бууруулахыг зорив. Залуучууд, өсвөр үеийнхний энэ хэрэгцээг хангах зорилгоор 2013 онд залууст ээлтэй эрүүл мэндийн 19 төв байгуулсан байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн Газар 2013 онд жендэрийн тэгш байдлыг сайжруулж, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх шинэлэг үйл ажиллагаа хэрэгжүүлэв. Ерөнхий сайдын удирддаг жендэрийн үндэсний хорооны чадавхийг тус хорооны ажлын албаны дэмжлэгтэйгээр сайжрууллаа. Монголын түүхэнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд анх удаагаа улсын төсвөөс хөрөнгө хуваарилав. Мөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 16 хоногийн аяныг амжилттай зохион байгуулж, олон нийт, хэвлэл мэдээллийнхний анхаарлыг хүчирхийллийн асуудалд хандууллаа. 16 хоногийн уг аяны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч 12 сарын 20-ны өдөр

ард түмэндээ хандан үг хэлж, Засгийн Газар, иргэний нийгэм, нийт Монголчуудыг гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоохыг уриалав.

Эцэст нь хэлэхэд, НҮБХАС нь Монгол Улсын Засгийн Газар, Швейцарийн хөгжлийн агентлаг болон Люксембургийн Засгийн Газартай хамтран 2013 онд Монгол улсад Залуучуудын хөгжлийг дэмжих анхны томоохон төслийг эхлүүлсэн юм. Энэ төслийн хүрээнд залуучуудын хөгжлийн эхний 15 төвийг нээж, эрсдэлт бүлгийн залуучуудад амьдрах ухааны сургалт явуулж, өөр бусад үйлчилгээ үзүүлж, үе тэнгийн хэдэн зуун сургагч нарыг бэлтгэв. Залуучуудын үе тэнгийн боловсролын үндэсний сүлжээ улс орон даяар өргөжин тэлж, 1100 орчим залуусыг эгнээндээ нэгтгэж, үе тэнгийнхэндээ хүрч үйлчлэн, сургалт зохион байгуулж, анхан шатны зөвлөгөө өгч, шаардлагатай үйлчилгээнд залуучуудыг холбон зуучилж байна. Мөн онд уг төслийн хүрээнд төлөвлөлт, төсөл, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад залуучуудын оролцоог сайжруулах механизмыг бий болголоо.

2014 онд уг төсөл үйл ажиллагааг эрчимтэй өргөжүүлж, залууст амьдрах ухааны чадвар олгож, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэж, залууст ээлтэй нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхийг зорьж байна.

2013 онд НҮБХАС-ын хүрсэн ололт амжилтуудын заримыг дараагийн хуудаснуудаас үзэж сонирхоно уу. Хүчээ нэгтгэснээр бид эх хүн амьдрал бэлэглэхийн төлөө энддэггүй, төрөлт бүр эсэн мэнд, залуу хүн бүр бүрэн хөгжиж, дэвждэг нийгмийг цогцлоох болно.



**НАОМИ КИТАХАРА**

**НҮБХАС-ийн Суурин төлөөлөгч**

## БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

### НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН

бүрэлдэхүүн хэсэг нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай үйлчилгээг тэгш хүртээмжтэй болгож, хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой. НҮБХАС нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ, эм хэрэгсэлийг ялангуяа сонгосон бүс нутгийн эмзэг бүлгийнхэнд хүртээмжтэй болгож Монголын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцооны бүхий л түвшинд нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг.



Гэрэл зурагчин: Дастин Бартер

### Монгол улс эхийн эндэгдлийг бууруулах Мянганы хөгжлийн зорилтоо биелүүлэв.

2015 он гэхэд эхийн эндэгдлийг 100,000 амьд төрөлт тутамд 50 болгож бууруулах мянганы хөгжлийн зорилтдоо Монгол улс 2013 онд хүрч, эхийн эндэгдлийг 100,000 амьд төрөлтөд 42,6 болгов. Мөн 2013 онд бид Люксембургийн Засгийн Газартай хамтран эрүүл мэндийн үйлчилгээг аймаг, сумын түвшинд сайжруулах зорилгоор улс орон даяар телемедицин буюу зайн оношлогооны сүлжээг суурилуулж дууслаа.

Эрүүл мэндийн салбарт технологийн энэхүү шинэ дэвшлийг нэвтрүүлсэн нь Монгол улсад эхийн эндэгдлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

### Монгол Улсын Засгийн Газар нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэлд зориулсан төсвөө нэмэгдүүлэв.

Тогтвортой өөрчлөлтийг хангах зорилгоор НҮБХАС нь 2012 болон 2013 онд Монгол Улсын Засгийн Газрыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэлд зориулсан төсвөө нэмэгдүүлэхийг зөвлөж, улмаар нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгсэлд хуваарилсан улсын төсөв 2014 онд бараг бараг 50 хувиар өсч, 83,000 ам.доллараас 124,000 ам.доллар болон нэмэгдэж, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээг хангах эрүүл мэндийн тогтолцооны чадавхи ихээхэн сайжрав. Тухайлбал, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний цэгүүдийн бараг 40 хувь нь жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслээр үнэгүй үйлчилж байна.

### Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтад жирэмслэлтээс сэргийлэх таван төрлийн эм хэрэгслийг оруулав.

НҮБХАС-ын ухуулга нөлөөллийн үр дүнд Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын газар жирэмслэлтээс сэргийлэх таван төрлийн эм хэрэгслийг эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтад оруулав. Ингэснээр жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн зах зээлийн үнэ бараг 57-83 хувиар буурч, иргэдийн дунд жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийн хүртээмж нэмэгдлээ.

**“Сум, дүүрэг бүрт хүрч үйлчилье” аяны хүрээнд хөдөөгийн 11,790 эмэгтэйд үйлчлэв.**



Гэрэл зурагчин: Дастин Бартер

*НҮБХАС эсэн мэнд амаржихуй, эх үрсийн төлөө ажилладаг.*

Зорилтот гурван аймаг, Улаанбаатар хотын нэг дүүрэгт НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр энэхүү аяныг амжилттай эхлүүлж, нөхөн үржихүйн насны 11,790 эмэгтэйд хүрч үйлчлэв. Гэр бүл төлөвлөлтийг дэмжих энэхүү аянаар дээр дурьдсан газруудад жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээ 2012 онд 41,9 хувь байснаа 2013 онд 48,8 хувь болж өссөн байна. Завхан аймагт НҮБХАС Японы ЖАЙКА байгууллагын сайн дурын ажилтнуудтай хамтран ажиллаж, хязгаарлагдмал чадавхи бүхий газруудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн техник, арга зүйн тусламж үзүүлэв.

**Монгол Улсын Засгийн Газар, НҮБХАС хамтран залууст ээлтэй эрүүл мэндийн 19 төв байгуулав.**

11 аймаг, Улаанбаатар хотын 5 дүүрэгт залууст ээлтэй эрүүл мэндийн 19 төв буюу “Ирээдүйн босго” өсвөр үеийн эрүүл мэндийн төвүүдийг байгуулав. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ нь өсвөр үе, залуучуудын онцлогийг анхаарч, үйлчлүүлэгчдийн нэр хүндийг хамгаалах тогтолцоогүй байсан учраас Монголд өсвөр үе, залуучууд энэ үйлчилгээг хүртэхэд ихээхэн бэрхшээлтэй байв. Харин өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгож, ялангуяа залуучуудтай

харьцах арга зүйд мэргэшсэн ажилтнууд уг үйлчилгээг үзүүлэх болсон нь эрүүл мэндийн үндэсний тогтолцоонд үлгэр дууриал болж байна. 2013 онд эдгээр төвүүд 5600 залууст үйлчилж, тодорхой үр дүнд хүрчээ. Тухайлбал, зорилтот Говь-Алтай, Завхан аймгуудад өсвөр насны охидын жирэмслэлтийн түвшин улсын дундажаас доош болж буурсан байна. Нууцлалыг хангах нь залуучуудын хувьд чухал асуудал бөгөөд эдгээр төвүүд нь үйлчлүүлэгчдийнхээ нууцлалыг сайтар чандлан хадгалдаг. Залуучуудын итгэлийг хүлээснээр эдгээр төвүүд нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд зогсохгүй жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдлуудыг шийдвэрлэдэг болж байна.

## ХҮН АМ БА ХӨГЖЛИЙН АСУУДЛЫГ УЯЛДУУЛАХ НЬ

**ХҮН АМ БА ХӨГЖЛИЙН** хөтөлбөрийн хүрээнд үндэсний болон орон нутгийн статистикийн газрууд хүн амтай холбоотой статистик тоон мэдээ, мэдээллийг бэлтгэн, хүртээмжтэй болгож, бодлого, төлөвлөгөө боловсруулагчид уг тоон мэдээллийг ашиглан, нотолгоонд суурилсан төлөвлөлт, үр дүнд тулгуурласан хяналт шинжилгээ үнэлгээ хийх чадавхитай болгоход дэмжлэг үзүүлдэг.

*“Нийгмийн тулгамдсан тодорхой асуудлаар УИХ-ын гишүүдийг мэдээллээр хангах, хүн ам ба хөгжил, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар гишүүд өөр хоорондоо болон иргэдтэй санал солилцох боломж олгоход НҮБХАС-тай хамтран хэрэгжүүлж буй энэ төсөл чухал ач холбогдолтой.” – Эрүүл мэндийн сайд асан, УИХ-ын даргын ахлах зөвлөх Др. С. Ламбаа*

**НҮБХАС шинээр байгуулагдсан яамтай нягт хамтран ажиллаж байна**

2012 онд Монгол Улсын Засгийн Газар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамыг байгуулав. Гол түншийн хувьд НҮБХАС уг яамтай ойр дотно хамтран ажиллах болсон юм. Хүн амын тоон мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, уг баримтад тулгуурлан хүн амын бодлого, хөтөлбөрийг боловсруулахад нь НҮБХАС техник, арга зүйн дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, одоо байгаа тоон мэдээ,

мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүн амын бодлого боловсруулж, улмаар залуучууд, ахмад настнуудын талаарх бодлогуудыг боловсруулахад нь НҮБХАС тус яаманд дэмжлэг үзүүлж байна.

### Дээд хэмжээний уулзалтаар Улаанбаатарын тунхаглалыг батлав.



Улаанбаатарын тунхаглалыг батлав.

НҮБХАС-ын нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд 2013 оны 9 сарын 30-ны өдөр Үндэсний дээд хэмжээний уулзалтаар Монгол улсын хүн ам ба хөгжлийн асуудлаарх Улаанбаатарын тунхаглалыг батлав. Улсын Их Хурлын гишүүд, бодлого боловсруулагчид, засгийн газрын албаны хүмүүс, иргэний нийгмийн байгууллагын тэргүүнүүд болон олон улсын байгууллагуудын төлөөлөлүүд оролцсон уг уулзалтаар хүн ам ба хөгжлийн асуудлаарх үндэсний ахиц дэвшлүүдийг хэлэлцэж, Ази, номхон далайн хүн амын бага хурлын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх алхамуудыг тодорхойлов. Улаанбаатар тунхаглалаар Монгол Улсын Засгийн Газар хүн ам ба хөгжлийн асуудлыг шийдвэрлэх урт хугацааны бодлого, стратегиудыг боловсруулах, тэдгээрийг үндэсний нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогуудтай уялдуулахаа амлав. Түүнчлэн уг тунхаглалаар үндэсний болон олон улсын хамтрагч талууд хүн ам ба тогтвортой хөгжлийн уядааг хангаж, бүх нийт түүний дотор өсвөр үе, залуучуудад зориулсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг устгахад хүчин чармайлтаа нэмэгдүүлэхээ амлав. Монгол Улсын Засгийн Газар одоо хүн амын талаар баримтлах үндэсний цогц бодлогоо (2014-2020) боловсруулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### НҮБХАС нь НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг эхлүүлэв.



Гэрэл зурагчин: Дастин Бартер

### Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2013 оны 9 сар

Үндэсний статистикийн хорооны ажилтнууд анх удаа цахим хэрэгсэл ашиглан, нийгмийн хөгжлийг тодорхойлох зорилгоор улс орон даяар өрхүүдээр явж, цогц тоон мэдээ, мэдээлэл цуглуулав. Урьд өмнө НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хийдэг байсан “Хүүхэд хөгжил судалгаа” болон НҮБХАС-ын дэмжлэгтэйгээр хийдэг байсан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааг нэгтгэж нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа хийхээр болсон. Энэ судалгаагаар бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, гэр бүл төлөвлөлт, өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлуудыг судаллаа. Бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой баримтыг 2014 онд гарах энэхүү судалгааны тайлангаас олж авах боломжтой.



## ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ: ХӨГЖЛИЙН ҮНДЭС



**ЖЕНДЭРИЙН** хөтөлбөрийн үндсэн зорилго нь бүх бодлого, хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах явдал юм. НҮБХАС нь улс төрчид, засгийн газрын гол байгууллагуудыг жендэрийн чиглэлээр чадавхижуулж, жендэрийн тэгш байдалд ахиц гаргах ухуулга, нөлөөлөл хийж, жендэрийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэсэн хуулиудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

*“Олон улсын хандивлагчид дэмжлэг тусалцаагаа зогсоосон энэ үед НҮБХАС бидэнтэй олон жилийн турш хамтран ажилласаар ирсэнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ) гүнээ талархаж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх төрийн үүргийг хуульчилж, хууль эрхзүйн орчныг шинэчлэх ухуулга нөлөөлөл хийхэд НҮБХАС манай байгууллагатай байнга хамтран ажиллаж ирэв.”*  
– ХЭҮТ-ийн захирал Д. Энхжаргал

### Жендэрийн тэгш байдлыг хангах явдлыг сайжруулах

Сүүлийн гурван жилийн хугацаанд НҮБХАС-аас хийсэн ухуулга нөлөөлөл, техник, арга зүйн дэмжлэг туслалцаа нь үндэсний хэмжээнд нөхөн үржихүйн эрх болон жендэрийн тэгш байдлыг хангах хууль эрхзүйн орчныг сайжруулж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлуулахад чухал хувь нэмэр оруулав. Уг хуулийг хэрэгжүүлэх стратеги, зорилт, нөөцийн хүрээг 2013 онд баталж, Монгол Улсын Засгийн Газраас анх удаа Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд хөрөнгө хуваарилав.

### Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд зориулсан нэг цэгийн үйлчилгээг НҮБХАС анх эхлүүлж, Засгийн Газар уг санаачлагыг дэмжин, үргэлжлүүлж байна.

НҮБХАС нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд зориулан 24 цагаар ажилладаг нэг цэгийн үйлчилгээний хоёр төвийг дэмжиж, нээсэн. Хүчирхийлэлд өртөгсөд уг төвд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хууль зүйн болоод сэтгэлзүйн зөвлөгөө авч, цагдаад гомдол мэдүүлэх боломжтой. Энэхүү санаачлагыг үргэлжлүүлэн Завхан, Говь-Алтай аймгийн засаг даргын тамгын газраас нэг цэгийн үйлчилгээний төвийг анх удаа санхүүгийн болон хүний нөөцөөр ханган ажиллуулахаар болов.

### 16 хоногийн аянаар Монгол улсын өнцөг булан бүрт хүрч ажиллаа.

ХЭҮТ болон НҮБХАС хамтран охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 16 хоногийн аяныг эхлүүлэв. Уг аянд хэдэн мянган хүн оролцож, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэхийг бодлого боловсруулагчдад уриалж, улмаар Монгол Улсын Ерөнхийлөгч гэр бүлийн хүчирхийллийг устгахад Монгол хүн бүр хамтран ажиллахыг уриалав. Энэ аян нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах үйл явцыг дэмжихэд чухал хувь нэмэр оруулав.

## ЗАЛУУЧУУДЫГ НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОЖ, ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ СОНГОХ ЧАДАВХИТАЙ БОЛГОХ НЬ

**ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН** хөтөлбөр нь Монголын залуучуудыг чадавхижуулан, нийгэм, эдийн засгийн огцом өөрчлөлтөд өртөмтгий эмзэг байдлыг бууруулж, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлогын орчныг сайжруулах зорилготой. Хөтөлбөрийн хүрээнд Швейцарийн хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн Газар, Монгол Улсын Засгийн Газар, АНУ-ын Энх тайвны корпус, Олон улсын хөгжлийн төлөөх Австралийн сайн дурынхантай хамтран ажиллаж байна. Олон талыг хамарсан уг хөтөлбөр нь залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ, амьдрах ухааны сургалтыг сайжруулж, жендэрийн тэгш байдлыг дэмжиж, залуучуудтай холбоотой бодлогуудыг боловсруулж, залуучуудад Монгол улсын хөгжилд идэвхитэй оролцоход шаардлагатай ур чадвар эзэмшүүлэхийг зорьж байна.

### **НҮБХАС Засгийн Газар болон залуучуудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэгүүдийг зохион байгуулав.**

2013 оноос хэрэгжиж эхэлсэн Залуучуудын хөгжлийн хөтөлбөр нь шийдвэр гаргах үйл явц дахь залуучуудын оролцоог нэмэгдүүлэх суурийг тавьж, залуучууд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамтай сар бүр уулзаж, залуучуудын үндэсний зөвлөлдөх уулзалтыг хийж, Монголын залуучуудын зөвлөлийг байгуулав. Энэ нь залуучуудын бодлогыг боловсруулахад тэдний санал дуу хоолойг бодлого боловсруулагчдад хүргэхэд чухал ач холбогдолтой. Сар бүрийн уулзалтын үр дүнд Монгол Улсын Засгийн Газарт залуучуудын асуудлаар зөвлөж, нөлөөлөх Монголын Залуучуудын ТББ-уудын Эвсэл байгуулагдав. Бидний хүсэж буй дэлхий ертөнц сэдвээр хийсэн Залуучуудын үндэсний зөвлөлдөх уулзалтад Монголын бүх аймгийн төлөөлөл оролцож, тэдний гаргасан зөвлөмжийг 2015 оноос хойшхи Хөгжлийн зорилтуудыг тодорхойлох олон улсын хэлэлцүүлэгт хүргүүлэв.

### **Залуучуудыг чадавхижуулж, амьдрах ухаан эзэмшүүлэх**

Төслийн хүрээнд залуучуудын хөгжлийн анхны төвийг 2013 онд байгуулж, залуучуудын хөгжлийг дэмжиж байгаа бөгөөд энэ нь амьдрах ухааны танхим, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ, үе тэнгийнхний сургалт бүхий цогц үйл ажиллагааны нэгээхэн хэсэг юм. Дархан хотод байгуулсан залуучуудын хөгжлийн анхны төв нь олон залуусын анхаарлыг татаж, амьдрах ухааны сургалт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт болон өөр олон ажлыг зохион байгуулж байна. 2014 оны эцэс гэхэд улс орон даяар нийт 15 төв байгуулахаар ажиллаж байна.

### **Залуучуудын үе тэнгийн боловсролын сүлжээ 2013 онд улам бүр хүрээгээ тэллээ.**

2013 онд Залуучуудын үе тэнгийн боловсролын сүлжээ өргөжин тэлж 15 аймагт 1,100 гаруй сайн дурын үе тэнгийн сургагч нар залууст ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний төвүүдтэй хамтран ажиллаж байна. Сайн дурын ажилтнуудын үүрэг гүйцэтгээд зогсохгүй үе тэнгийн сургагч нар нь үе тэнгийнхэндээ бэлгийн болон нөхөн үржихүйн сургалт, анхан шатны зөвөлгөө, зуучлах үйлчилгээ үзүүлж, нөхөн үржихүйн эрхийн талаар мэдлэг олгох ажлуудыг хийж байна. Үе тэнгийн сургагч нар залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг залуучууд ялангуяа эрсдэлт бүлгийн залуучуудтай холбоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

### Сургалтын хөтөлбөрийг шинэчлэв




НҮБХАС өсвөр үе, залуучуудад зориулсан амьдрах ухааны боловсролыг дэмждэг.

НҮБХАС, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөрийн яамтай хамтран мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /МСҮТ/, их

сургуулийн сургалтын хөтөлбөрт амьдрах ухаан, ялангуяа эрүүл мэнд, харилцааны ур чадварыг тусгах ажлыг эхлүүлээд байна. МСҮТ-ийн оюутнуудын амьдрах ухааны чадварыг сайжруулахаар сургалтын хөтөлбөрийг нь шинэчилсэн бол их сургуулийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл нь ирээдүйн нийгмийн ажилтнуудад залуучуудтай ажиллаж, тэднийг дэмжих арга зүй, ур чадвар эзэмшүүлэхийг зорьж байна.

Мөн үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг шинэчилж, 2014 онд уг шинэчлэлийг хийж дуусгахаар ажиллаж байна. МСҮТөвд элсэн орж буй олон залуус сургалтын хөтөлбөрийн энэхүү шинэчлэлийн үр шимийг хүртэж, залуучууды хөгжлийн төвүүд нь алслагдсан эмзэг бүлгийн залуучуудад хүрч үйлчлэх юм.

### Монгол Улсын Засгийн Газар болон НҮБХАС-гийн Улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөр 2012-2016



## НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН 2013 ОНЫ ТАЙЛАН

ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД	Хүн ам ба хөгжил	Нөхөн үржихүйн эрүүл мэнд	Залуучууд	Жендэр
<b>Засгийн Газар</b>				
Эрүүл мэндийн яам				
Боловсрол, шинжлэх ухааны яам				
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам				
Хөдөлмөрийн яам				
Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар				
Жендэрийн үндэсний хороо				
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв				
<b>Улсын Их Хурал</b>				
УИХ-ын тамгын газар				
Үндэсний статистикийн хороо				
<b>Төрийн бус байгууллагууд</b>				
МОНФЕМНЕТ				
Монголын оюутны холбоо				
Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг				
Монголын улаан загалмай нийгэмлэг				
Иргэний боловсролын төв				
Монголын залуучуудын холбоо				
<b>Боловсролын байгууллагууд</b>				
Жонс Хопкинсийн их сургуулийн Блумберг нийгмийн эрүүл мэндийн сургууль				
Хүн амын сургалт, судалгааны төв				
Монгол улсын эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль				
<b>Бусад түншүүд</b>				
Залуучуудын үе тэнгийн боловсролын үндэсний сүлжээ				
НҮБ-ын залуучуудын зөвлөх хороо				

### 2013 оны санхүүгийн гүйцэтгэл Хуваарилсан хөрөнгө, зардлын хураангуй (ам.доллараар)

	Төсөв	Зардал	Баланс	Гүйцэтгэл хувь
Байнгын эх үүсвэр	2,564,478	2,557,583	6,895	99,7%
Бусад эх үүсвэр	2,405,141	2,285,251	122,794	95%
Институцийг дэмжих төсөв	548,591	524,513	24,078	96%
Бүгд	5,521,114	5,367,347	153,767	97%

## Хөгжлийн түншүүд

Хандивлагчид	Төсөв	Зардал	Баланс	Гүйцэтгэл хувь
Люксембургийн Засгийн Газар (1)	1,073,892	973,615	100,278	91%
*Люксембургийн Засгийн Газар (2)	462,390	455,037	7,353	98%
НҮБХАС-ын нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн тогтвортой хангамжийн глобаль сан	437,488	438,179	691	100%
Швейцарийн хөгжлийн агентлаг	363,316	343,336	19,980	95%
Билл болон Мелинда Гейтс нарын сан	43,833	43,082	804	98%
Хүний аюулгүй байдлын итгэлцлийн сан	24,222	24,219	3	100%
<b>Нийт дүн</b>	<b>2,405,141</b>	<b>2,277,414</b>	<b>127,727</b>	<b>95%</b>

\*\*\* Жич: (1) Эх, нярайн эрүүл мэндийн тусламжид зайн оношлогооны дэмжлэг үзүүлэх төсөл  
(2) Залуучууд, хөдөлгөөнт болон эрсдэлт хүн амыг ХДХВ, бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх төсөл

## 2013 оны байнгын эх үүсвэрийн хуваарилалт, бүрэлдэхүүн хэсгээр



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

**3 дугаар сарын 8** *Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр:* НҮБХАС –ын суурин төлөөлөгч охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах төрийн үүргийг онцлов.

**3 дугаар сарын 19/ 20** НҮБХАС 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтуудыг тодорхойлох залуучуудын үндэсний зөвлөлдөх уулзалтыг НҮБ-ын байранд зохион байгуулж, Монгол улсын өнцөг булан бүрээс 80 залуус Улаанбаатарт хуран цуглаж, дуу хоолойгоо хүргэж, санал солилцлоо.

**4 дүгээр сарын 25** НҮБХАС, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

**5 дугаар сарын 5** *Олон улсын эх баригчдын өдөр:* НҮБХАС эсэн мэнд амаржихуйд эх баригч нарын оруулж буй хувь нэмэр, хүчин чармайлтыг онцлов.

**5 дугаар сарын 20** Монгол улсын өнцөг булан бүрээс ирж залуучуудын үндэсний чуулганд оролцож буй 800 гаруй төлөөлөгчдөд хандаж НҮБХАС-ын суурин төлөөлөгч үг хэлэв.

**7 дугаар сарын 8** *Дэлхийн хүн амын өдөрт* зориулж хэвлэлийн бага хурал зохион байгуулж, өсвөр үеийнхний жирэмслэлтийн тухай баримтат киноны нээлт хийв. Монголын оюутны холбоо өсвөр үеийнхний жирэмслэлтийн асуудлаархи 6 сарын аянг НҮБХАС-ын дэмжлэгтэйгээр эхлүүлэв.

**8 дугаар сарын 1** Швецарийн хөгжлийн агентлагаас зохион байгуулсан төслийн тэмцээнд залуучуудын хөгжлийн хөтөлбөр 1 дүгээр байр эзлэв.

**8 дугаар сарын 1** Монгол улсад шинээр томилогдсон НҮБХАС-ын суурин төлөөлөгч хатагтай Наоми Китахара итгэмжлэх захидлаа гадаад харилцааны сайд Л.Болдод өргөн барив.

**8 дугаар сарын 12** *ТББ, засгийн газрын байгууллагууд, НҮБХАС болон 2000 гаруй залуус олон улсын залуучуудын өдрийг Чингис хааны талбайд хамтран тэмдэглэв.* Уг өдөр залуучууд төрөл бүрийн байгууллагуудын мэдээллийн булангаар зочилж, амьд хөгжим сонсож, өдрийг сонирхолтой өнгөрүүллээ.

**8 дугаар сарын 14** Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, НҮБХАС түншүүдийнхээ хамт Дархан –Уул аймагт залуучуудын хөгжлийн төвийг нээв.



**8 дугаар сарын 15** НҮБХАС-ын суурин төлөөлөгчийн газар Монгол улсад эх, нярайн эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн яаманд гардуулав.

**8 дугаар сарын 29** Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх талаар Хятад, Монголын хамтран хэрэгжүүлж буй төслийг эрчимжүүлэх асуудлаар Хятад, Монголын хэрэгжүүлэгч байгууллагууд НҮБ-ын байранд уулзав.

**9 дүгээр сарын 20** Монгол дахь НҮБХАС жендэрийн тэгш байдал, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар анхны Twitter ярилцлагыг зохион байгуулав.

**9 дүгээр сарын 22** ХДХВ/ДОХ-оос сэргийлэх галт тэрэгний сурталчилгааны аяныг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Монголын улаан загалмай нийгэмлэг, НҮБХАС хамтран эхлүүлэв.

**9 дүгээр сарын 30** Үндэсний дээд хэмжээний уулзалтаар Улаанбаатарын тунхаглалыг батлав.

**10 дугаар сарын 10** Эх хүүхдийн эрүүл мэндийн тандалт судалгааны тогтолцоо болон ургийн оношлогоо сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалт боллоо.



**11 дүгээр сарын 21** Эрүүл мэндийн яам, НҮБХАС хамтран Дэлхийн хүн амын байдал тайланг, Монгол улсын талаарх тойм мэдээллийн хамт танилцуулав.

**11 дүгээр сарын 22** НҮБ-ын Залуучуудын зөвлөлдөх хороо, НҮБХАС-тай хамтран өсвөр үеийнхний жирэмслэлтийн талаар кино ярилцлага зохион байгуулав.

**11 дүгээр сарын 25** Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг эхлүүлж, хэвлэлийн бага хурал зохион байгуулан, фото үзэсгэлэн гаргав.

**12 дугаар сарын 1** *ДОХ-той тэмцэх дэлхийн өдөр*: ХДХВ/ДОХ-ын асуудлаарх хэлэлцүүлэгт НҮБ-ын бүх төрөлжсөн байгууллага, Эрүүл мэндийн дэд сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга оролцов.

**12 дугаар сарын 7** НҮБХАС, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, UBS Music хөтөлбөр хамтран жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх тоглолт зохион байгуулав.

**12 дугаар сарын 10** Хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян олон улсын хүний эрхийн өдөр өндөрлөв.

**12 дугаар сарын 20** Монгол Улсын Ерөнхийлөгч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохыг иргэний нийгэм, парламент, бүх монголчуудад уриалав.

